

# 2023 | Тогтвортой хөгжлийн тайлан

MCS интернэйшнл

# Агуулга


## Эхлэл

1 Агуулга
2 Өмнөх үг

## Засаглал

3 Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдах нь
4 Тогтвортой хөгжлийн оролцогч талууд
5 Ёс зүйн бодлого
6 Нэгдсэн удирдлагын тогтолцоо
7 Зөвшөөрөл, нийцлийн менежмент
8 Эрсдэлийн менежмент
9 Хяналтын менежмент

## Нийгэм

10 Эдийн засагт оруулсан хувь нэмэр
11 Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт
12 Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин
13 Эрх тэгш хөдөлмөрийн орчин
14 Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
15 Сургалт, хөгжил
16 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
18 Ажилтнуудын сайн сайхан байдал
20 Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо
21 Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ

## Байгаль орчин

22 Байгаль орчны менежмент
23 Эрчим хүчний хэмнэлт
24 Түлшний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарал
25 Усны менежмент ба хэмнэлт
26 Ногоон байгууламж
27 Хог хаягдлын менежмент

Эхлэл
Агуулга
• Өмнөх үг
Засаглал
Нийгэм
Байгаль орчин

# Өмнөх үг



М Си Эс интернэйшнл ХХК нь байгаль орчин болон нийгэмдээ ээлтэй, ёс зүйтэй үйл ажиллагаа эрхэлж, ямагт тогтвортой хөгжилд чиглэнэ.

Хүндэтгэсэн, Ч.Даваахүү
М Си Эс интернэйшнл ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Бид сэргээгдэх эрчим хүчний судалгаа хөгжүүлэлт хийж, улсынхаа тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулна.

Хүндэтгэсэн, Д.Алтантулга
М Си Эс интернэйшнл ХХК-ийн
Тэргүүн дэд захирал



Компанийн бүх оролцогч талуудын эрх тэгш байдлыг хүндэтгэж, хүний эрхийг дэмжин, нийгмийн тогтвортой хөгжилд зэрэг, бодитой хувь нэмэр оруулна.

Хүндэтгэсэн, Т.Оюун-эрдэнэ
М Си Эс интернэйшнл ХХК-ийн
хүний нөөц хариуцсан захирал

Эхлэл
Засаглал
- Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдах нь
- Тогтвортой хөгжлийн оролцогч талууд
- Ёс зүйн бодлого
- Нэгдсэн удирдлагын тогтолцоо
- Зөвшөөрөл, нийцлийн менежмент
- Эрсдэлийн менежмент
- Хяналтын менежмент
Нийгэм
Байгаль орчин

# Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдах нь

- НҮБ-ын тодорхойлсон тогтвортой хөгжлийн 17 зорилго (ТХЗ)-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэн ажилладаг. Байгаль орчин болон нийгэмдээ ээлтэй үйл ажиллагаа явуулахыг чухалчилдаг.
- Байгаль орчин, нийгэм, засаглалын хороог 2023.11.20-нд байгуулж, баталлаа.
ТХЗ-ыг Компанийн бизнесийн онцлогт уялдуулан үйл ажиллагаандаа дараах байдлаар нийцүүлж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

## Нийгмийн хувьд:

- Хүний эрхийг дээдэлсэн, эрх тэгш, олон янзат, хүртээмжтэй хөдөлмөрийн харилцааг бүрдүүлэхийг зорьдог.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоотой.
- Хариуцлагатай, тогтвортой нийлүүлэгч, харилцагчдыг дэмжихийг эрмэлздэг.
- Нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулдаг.
- Хариуцлагатай үйлдвэрлэл, шинэ технологи нэвтрүүлэхийг ямагт зорьдог.
- Бүтээгдэхүүний чанар, найдвартай байдлыг хангаж ажилладаг.

## Засаглалын хувьд:

- Бизнесийн ёс зүйн дүрмийг хэрэгжүүлдэг.
- Нэгдсэн удирдлагын тогтолцоотой.
- Эрсдэл ба нийцлийн менежментийн тогтолцоотой.
- М-Си-Эс Группийн "Авлигаас урьдчилан сэргийлэх журам"-ыг мөрдөж ажилладаг.
- Ил тод байдлыг хангаж, тогтвортой хөгжлийн тайланг жил бүр бэлтгэн, нээлттэй байршуулдаг.

## Байгаль орчны хувьд:

- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулдаг.
- Эрчим хүчийг хэмнэхэд онцгой анхаардаг.
- Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалтад манлайлан оролцдог.
- Байгалийн нөөцийг зохистой хэрэглэдэг, усны хэрэглээг бодитоор хэмнэсэн.
- Хог хаягдлын зөв, зохистой хэрэглээний менежменттэй.

## Тогтвортой хөгжлийн зорилтууд:



# Тогтвортой хөгжлийн оролцогч талууд

- Бизнесийн үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тогтолцоог хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлан бүх оролцогч талын эрх ашиг, хамтын оролцоо, харилцааг чухалчлан хамтран ажилладаг.
- Тэдгээр оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн БОНЗ-ын төрөл бүрийн мэдээллийг олон сувгаар дамжуулан харилцаж, гарсан санал, дүгнэлтэд суурилан байнга сайжруулсаар байна.



Эхлэл
Засаглал
Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдах нь
Тогтвортой хөгжлийн оролцогч талууд
• Ёс зүйн бодлого
Нэгдсэн удирдлагын тогтолцоо
Зөвшөөрөл, нийцлийн менежмент
Эрсдэлийн менежмент
Хяналтын менежмент
Нийгэм
Байгаль орчин




## Ёс зүйн бодлого

- Бид бизнесийн үйл ажиллагаандаа М-Си-Эс Группийн үнэт зүйлс, баримтлах зарчмууд болон тэдгээрээс урган гарсан “Ёс зүйн дүрэм”-ийг мөрдлөг болгоно.
  - Компанийн хүрээнд ёс зүйн дүрмийг сахиулах үүрэг бүхий Ёс зүйн хороотой.

- Группийн "Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам"-ыг мөрдөж ажилладаг.
  - 223 гэрээлэгчид авлигын эсрэг шаардлагыг танилцуулан, баталгааг гаргуулсан.
  - Нийт удирдах ажилтнуудаас жилд 2 удаа бусдаас авсан болон өгсөн бэлэг, урамшууллын зүйлийн бүртгэлийг хийлгэлээ.

- Ажилтан нь Монгол Улсын хууль, тогтоомж болон Ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн, шударга бус үйлдлийн талаар нэр, хаяггүйгээр шийдвэрлэх эрх бүхий ажилтанд мэдээллийг амаар, цахим шуудангаар болон санал, гомдлын хайрцагт бичгээр хүргүүлэн шийдвэрлүүлэх боломжтой. Мэдээллийн нууцлалыг хадгалан, зохих журмын дагуу шийдвэрлэдэг.
  - Тайлант онд ёс зүйтэй холбоотой зөрчлийн гомдол ирээгүй.

Эхлэл
Засаглал
Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдах нь
Тогтвортой хөгжлийн оролцогч талууд
Ёс зүйн бодлого
• Нэгдсэн удирдлагын тогтолцоо
Зөвшөөрөл, нийцлийн менежмент
Эрсдэлийн менежмент
Хяналтын менежмент
Нийгэм
Байгаль орчин

# Нэгдсэн удирдлагын тогтолцоо (НУТ)

- Бид 2004 оноос хойш олон улсын стандартуудыг нэвтрүүлэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа байнгын сайжруулж байна.
  - 5 дахь жилдээ НУТ-ны гэрчилгээ эзэмших эрхээ олон улсын эрх бүхий Австралийн "BCert" компаниар амжилттай магадлан баталгаажууллаа.
  - Стандартын "төлөвлө, хий, шалга, сайжруул (PDCA)" циклийн дагуу жил бүрийн дотоод аудитын үр дүнд сайжруулалтууд хийгдэж үнэ цэнийг бий болгосоор байна.

- НУТ-ны стандартууд:

ISO 9001:2015 | ISO 14001:2015 | ISO 22000:2018 | ISO 45001:2018 | ISO 50001: 2018

- НУТ-ны стандартуудаас гадна:
  MNS ISO/IEC 17025: 2017 "Сорилт, шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага"-ын дагуу
  - Түлш, тос, уур-усны химийн шинжилгээний лаборатори,
  - Дулааны даралтын хэмжлийн лабораториуд тус тус итгэмжлэгдсэн.

  - ISO 27001: 2020 Мэдээллийн аюулгүй байдал (МАБ)-ын стандартын хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд принтерүүдэд "uF online" систем нэвтрүүлснээр МАБ-ыг илүү сайжруулсан.

**111**
Үйл явц сайжруулалт

**6**
Дотоод аудит

**128**
Сургалтад хамрагдсан ажилтан

**90%**
Захиалагчийн сэтгэл ханамж

**2**
Хөндлөнгийн аудит

**93%**
ЦЭХ хэрэглэгчдийн сэтгэл ханамж

Эхлэл
Засаглал
Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдах нь
Тогтвортой хөгжлийн оролцогч талууд
Ёс зүйн бодлого
Нэгдсэн удирдлагын тогтолцоо
• Зөвшөөрөл, нийцлийн менежмент
Эрсдэлийн менежмент
Хяналтын менежмент
Нийгэм
Байгаль орчин

## Зөвшөөрөл, нийцлийн менежмент

- Эрчим хүч болон уул уурхайн дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулдаг Компанийн хувьд:
  - Монгол Улсын хууль, зохицуулалт, тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагыг хангаж ажиллалаа.
  - Ашиглалтын бизнесийн үйл ажиллагааг эрхэлдэг салбар, нэгж бүр өөрийн мөрдөх хууль, зохицуулалтын шаардлагыг дотооддоо хянаж, зөрчил гарахаас урьдчилан сэргийлдэг.
  - Нийцлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг удирдлагын багт жилд 2 удаа тайлагналаа.
  - Нийцлийн сургалтыг жил бүр зохион байгуулж хэвшсэн.
- М-Си-Эс Группийн Нийцлийн бодлого, Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, Улс төрийн хандивын журам, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам, Компанийн "Нийцлийн журам"-ын хүрээнд нийцлийн соёлыг бүрдүүлэх, эрсдэлийг удирдаж, сайжруулах, илүү үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллалаа.
  - Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, ажилтнуудаас зөрчлийн мэдүүлгийг авч, үр дүнг тайлагнаж ажилласан.

**13**
Сунгуулсан тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөл

**80%**
Зөрчлийн мэдүүлэгт хамрагдсан ажилтан



Эхлэл
**Засаглал**
Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдах нь
Тогтвортой хөгжлийн оролцогч талууд
Ёс зүйн бодлого
Нэгдсэн удирдлагын тогтолцоо
Зөвшөөрөл, нийцлийн менежмент
• **Эрсдэлийн менежмент**
Хяналтын менежмент
Нийгэм
Байгаль орчин

## Эрсдэлийн менежмент

- Компанийн бүх салбар, төсөл, нэгжүүдийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг мэдээлэх, хянах систем бүх ажилтанд нээлттэй, хүртээмжтэй байдлаар хангагдсан байдаг. Бид 2023 онд эрсдэлийн менежмент (ЭМ)-ийн тогтолцоогоо илүү сайжруулан ISO 31000: 2018 стандартад нийцүүлэх зорилго тавьж ажиллалаа.

- Зохицуулалтын гол баримт бичиг болох ЭМ-ийн журмаа 2023.12.20-нд шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгосон.
- ЭМ-ийн тогтолцоо хариуцсан нэгжтэй бөгөөд НУТ-ны багийн гишүүдээс нэгжүүдэд дэмжлэг үзүүлж, манлайлан ажилладаг.
- Компанийн стратегийн болон байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын эрсдэлүүдийг тодорхойлж, удирдлагын багаар хэлэлцүүлэн хянадаг. Үүний хэрэгжилтийг удирдлагын зүгээс төлөөлөн удирдах зөвлөлд жил бүр тайлагнах үүрэгтэй оролцдог.
- Сар, улирал, хагас жилийн давтамжтай эрсдэлийн мэдээллийг компанийн бүх түвшний ажилтнуудад хүргэж стандартын суурь зарчмыг хэрэгжүүлж хэвшсэн.
- ЭМ-ийн үйл явц дахь цаасан тайлан, баримт бичгүүдийг цахимжуулж ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн.

**27**
Эрсдэлийн аппликейшн ашигладаг баг, нэгж

**42**
Удаагийн тайлан, мэдээ

**70**
БОНЗ-ын эрсдэлийг бууруулсан

**6**
Нэг ажилтанд ногдох сургалтад зарцуулсан цаг

**40**
ЭМ-ийг үр дүнтэй хэрэгжүүлсэн баг, нэгж (давхардсан тоо)

# Хяналтын менежмент

- Байгууллагын заавал дагаж мөрдвөл зохих хууль тогтоомж, дүрэм журам, норм, стандартуудын шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавьж, болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор "Хяналтын ерөнхий журам"-ын дагуу чиг үүрэг хариуцсан нэгж жил бүр дотоод хяналтыг төлөвлөн зохион байгуулдаг.

- 2023 оны дотоод хяналтын хөтөлбөр, удирдамжийн дагуу ажиллав.

- Хяналтын үйл ажиллагааны хэрэгжилт болон процесс сайжруулалтыг жилд 2 удаа удирдлагуудад тайлагнадаг.

- Нийт 194 шаардлагын дагуу 2 удаа дотоод хяналт хийгдсэн.

- Үр дүнд үйл ажиллагааг сайжруулах ажлуудыг төлөвлөн, хэрэгжилтийг сар бүр хянаж, мэдээлж хэвшсэн.

- БОНЗ-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дахин давтагдахгүй байх үүднээс эргэн хяналтыг хэвшүүлэхэд анхаарч ажиллалаа.

- БОНЗ-ын гол оролцогч тал болох Диспетчерийн үндэсний төв ТӨХХК болон Энержи Ресурс компанийн нийцлийн хяналтад хамрагдаж сайжруулах боломжуудыг бүрэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

| 15 | 194 | 2 | 25 |
|---|---|---|---|
| Удаагийн мэдээлэл, тайлан | Дотооддоо хянасан хуулийн шаардлага | Удаагийн дотоод хяналт | Чиглэлийн хөндлөнгийн хяналт |

Эхлэл

Засаглал

**Нийгэм**

- **Эдийн засагт оруулсан хувь нэмэр**
- Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт
- Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин
- Эрх тэгш хөдөлмөрийн орчин
- Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
- Сургалт, хөгжил
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- Ажилтнуудын сайн сайхан байдал
- Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо
- Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ

Байгаль орчин


# Эдийн засагт оруулсан хувь нэмэр

Монгол Улсын Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас хамтран тухайн жилийн нийгэм, эдийн засагт оруулсан хувь нэмрийг үнэлж эрэмбэлэн шалгаруулдаг ТОП 100 аж ахуй нэгж байгууллагаар бид 7 дахь жилдээ шалгарлаа.




Улсын төсөв төвлөрүүлсэн татвар шимтгэлийн дүн (тэрбум төгрөг)




Хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүч

**↑31%**

**↑19%**

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн



Эхлэл
Засаглал
**Нийгэм**
Эдийн засагт оруулсан хувь нэмэр
• **Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт**
Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин
Эрх тэгш хөдөлмөрийн орчин
Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
Сургалт, хөгжил
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
Ажилтнуудын сайн сайхан байдал
Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо
Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ
Байгаль орчин



## Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт

- АЛТАЙ 10 МВт НАРНЫ ЦАХИЛГААН СТАНЦЫН ТӨСӨЛ

"Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого"-ын хүрээнд сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг 2030 онд 30%-д хүргэх зорилтыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулав.

- Алтай-Улиастайн эрчим хүчний систем хэрэглэгчдийг байгаль орчинд ээлтэй ногоон эрчим хүчээр хангаж эхэллээ.
- Эрчим хүчний системд хүчдэлд залгагдсан огноо: 2023.11.13

Төслийн хүрээнд:
- Алтай 10 МВт нарны цахилгаан станц,
- 35/35 кВ дэд станц ба 6.5 км урттай 35 кВ цахилгаан дамжуулах агаарын шугам, Есөнбулаг 110/35/6 кВ дэд станцын өргөтгөлийн ажлуудыг гүйцэтгэсэн.

**17**
Сая кВт.цаг цэвэр эрчим хүчийг жилд үйлдвэрлэнэ.

**15**
Мянган тонноор хүлэмжийн хийн хэмжээг жилд бууруулна.

Эхлэл
Засаглал
**Нийгэм**
Эдийн засагт оруулсан хувь нэмэр
Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт
• **Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин**
Эрх тэгш хөдөлмөрийн орчин
Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
Сургалт, хөгжил
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
Ажилтнуудын сайн сайхан байдал
Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо
Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ
Байгаль орчин

# Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин

- Бид ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг дээдэлж, бүхий л үйл ажиллагаандаа хүний эрх, эрх тэгш байдал, олон талт байдлыг хүндэтгэх үндсэн зарчмыг баримтлан ажилладаг. Үүний зэрэгцээ бид нийгмийн сайн сайхны төлөө манлайлан, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг. Байгаль орчин, нийгэм, засаглалын жишигт нийцүүлэн олон талт, хүртээмжтэй хөдөлмөрийн орчин бүрдүүлэх нь бидний зорилт юм.

**↑33%** Нийт эмэгтэй ажилтны эзлэх хувь

**67%** Нийт эрэгтэй ажилтны эзлэх хувь

| | |
|---|---|
| Boomers I /1946-1954/ | 1 |
| Boomers II /1955-1964/ | 13 |
| Gen X /1965-1980/ | 68 |
| Gen Y /1981-1996/ | 337 |
| Gen Z /1997-2012/ | 247 |

**26** Нийт удирдах эмэгтэй ажилтны тоо

**↑23** Ялгаатай хэрэгцээтэй ажилтан

**73** Нийт удирдах эрэгтэй ажилтны тоо

**4.3** Нийт ажилтны сэтгэл ханамж (4.3 /5)



Тайлбар: ↑ 2022 оноос 2 нэгжээр өссөн.

## Эрх тэгш хөдөлмөрийн орчин

- Хүний эрх тэгш, олон талт байдлыг дээдэлсэн аюулгүй, эрүүл ажлын орчин бүрдүүлж, нийгмийн оролцоог дэмжин ажиллав.

- Хөдөлмөрийн тухай хууль болон БОНЗ-ын суурь зарчмуудыг тусгасан М-Си-Эс Группийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг баримталж, хүний эрхийг хүндэтгэсэн хөдөлмөрийн харилцааны орчин бүрдүүлэхийг зорьж ажиллалаа.

- Тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудын туршлага, мэдлэгийг залуу үедээ өвлүүлэн үргэлжлүүлэн ажиллуулж, тэдний хөдөлмөр эрхлэлт, нийгэмд оруулах хувь нэмрийг дэмжиж байна.

- Оюу Толгой төслийн барилга угсралтанд ажиллаж буй эмэгтэй ажилтнуудын хөдөлмөрийн нөхцлийг сайжруулж, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаснаар эмэгтэйчүүдэд ээлтэй, аюулгүй ажлын орчныг бүрдүүлэхэд бодитой ахиц гаргалаа.

- Ажилтнууддаа сайн дурын ажил, гэр бүлийн үүрэг хариуцлага, хувийн сонирхол, эрүүл мэнддээ цаг гаргах боломжийг олгох зорилгоор цалинтай чөлөө, уян хатан ажлын цагийн хуваарь, гэр бүл болон хүүхэдтэй болсон ажилтанд бэлэг олгох зэрэг олон талт хөнгөлөлтийг хэрэгжүүлсэн.

**↑168**

Ажлын байраар хангасан орон нутгийн иргэд

**3**

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой шинэчлэгдсэн журам

**33%**

Менежментийн багийн эмэгтэй гишүүд

**67%**

Менежментийн багийн эрэгтэй гишүүд

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн

Эхлэл
Засаглал
Нийгэм
Эдийн засагт оруулсан хувь нэмэр
Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт
Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин
Эрх тэгш хөдөлмөрийн орчин
• Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
Сургалт, хөгжил
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
Ажилтнуудын сайн сайхан байдал
Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо
Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ
Байгаль орчин



↑ 203

Хүн шинээр ажилд орсон

↑ 783

Бий болгосон шууд бус ажлын байр

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн

## Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин

- Бид "Ялгаатай хэрэгцээтэй ажилтны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого"-той бөгөөд холбогдох хууль, тогтоомжийн нийцлийг хангаж ажиллалаа.
  - Манай компанийн ажилтнуудын 3.5%-ийг ялгаатай хэрэгцээтэй хүмүүс эзэлж байна.
  - Олон талт байдал болон гэр бүлд ээлтэй, хүртээмжтэй орчинг бүрдүүлэх, сайжруулах талаар судалгаа хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэс суурийг тавьсан.
  - Ажилтнуудын ажил, амьдралын тэнцвэрийг хангах, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор зайнаас ажиллах, ажлын цагийг богиносгох, уян хатан цагийн хуваарь зэрэг олон төрлийн сонголтыг санал болгож байна.
  - Өмнөговь аймагт ажлын байрны нээлттэй өдөрлөг зохион байгуулж, орон нутгийн иргэдэд ажлын байр бий болгох, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулсан.

# Сургалт, хөгжил

- Бид сургалт, хөгжилд хөрөнгө оруулалт хийж, ажилтнуудын хөгжлийг дэмжиж ажиллав. Сургалтад хамрагдсан нийт ажилтны 82% нь эмэгтэй ажилтан байв.

  Ажилтны хөгжлийг дэмжих, манлайлал ба харилцааны ур чадварыг хөгжүүлэх хүрээнд:
  - Хувь хүний болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор М-Си-Эс Академи болон гадны мэргэжлийн байгууллагын сургалт,
  - Удирдах ажилтнуудын манлайлах ур чадварыг хөгжүүлэх зөвлөгөөн,
  - Өглөөний цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, туршлага түгээх "Sunrise MCSI" хөтөлбөр,
  - Ажлын байрны харилцааны соёлыг дээшлүүлэх "Everyday Respect" зэрэг сургалтуудыг зохион байгуулсан.
  - Хүний нөөцийн удирдлагын чиглэлээр БНСУ-д зохион байгуулагдсан "Global HR Forum"-д ажилтнуудаа оролцуулж, олон улсын туршлага судлах, мэдлэг, чадвараа дээшлүүлэх боломжийг олгосон.

- Боловсролын салбарт оруулсан хувь нэмэр:
  - "Хүний нөөцийн менежментийн улсын XIII олимпиад"-ыг ивээн тэтгэж, оюутнуудад мэргэжлийн чиглэлээр хөгжихөд нь дэмжлэг үзүүлсэн.
  - Ирээдүйн мэргэжилтнүүдийг бэлтгэх цалинтай оюутан дадлагажуулах "MCS Internship" хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, 9 оюутанд ажлын туршлага олгосон.

| ↑682 | ↑3,132 | ↑63 | 51 |
|---|---|---|---|
| Сая төгрөгийн сургалт, хөгжлийн зардал | Цагийн сургалт | Албан тушаал дэвшсэн ажилтан | Сургалт, хөгжүүлэлт |

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн

Эхлэл
Засаглал
**Нийгэм**
Эдийн засагт оруулсан хувь нэмэр
Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт
Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин
Эрх тэгш хөдөлмөрийн орчин
Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
Сургалт, хөгжил
• **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй**
Ажилтнуудын сайн сайхан байдал
Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо
Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ
Байгаль орчин

# Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

- Бид үйл ажиллагаандаа Компанийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин (ХАБЭАБО)-ы бодлого" баримталдаг бөгөөд дараах зохицуулалтын баримт бичгүүдийг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.
  - ХАБЭАБО-ы зорилт, төлөвлөгөө
  - Ажлын байрны үзлэг, шалгалтын журам
  - Онцгой байдлын үед бэлэн байх болон хариу арга хэмжээ авах төлөвлөгөө
  - Гамшгийн төлөвлөгөө
  - Химийн бодисын ослын үед ажиллах төлөвлөгөө
- ХАБЭАБО-ы зөвлөл 2023.4.28-нд байгуулагдаж, үйл ажиллагааныхаа хэрэгжилтийг удирдлагын багт тайлагнаж ажиллалаа.
- ХАБЭАБО-ы эрсдэлийг бууруулах зорилгоор хийгдсэн ажлуудаас:
  - Өмнөговь дахь цахилгаан станцын автомат гал унтраагуурууудыг бүрэн шинэчилсэн.
  - Станцын галын дохиоллуудыг мэргэжлийн байгууллагаар шалгуулж туршсан.
  - Ажлын байрны үзлэг болон аюулыг мэдээлэх процессыг автоматжуулснаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн.

**0.097**
LTIFR- 100 ажилтанд ногдох хугацаа алдсан гэмтлийн давтамж (↑)

**2**
Сая хүн/цаг хөдөлмөрийн чадвар түр алдалтгүй ажилласан (↑)

**84**
Сая төгрөгийн ХАБЭА-н сургалтын зардал (↑)

**347**
ХАБЭА-н сайжруулалтын ажлууд (↓)

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн, ↓ 2022 оноос буурсан.



Эхлэл
Засаглал
Нийгэм
Эдийн засагт оруулсан хувь нэмэр
Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт
Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин
Эрх тэгш хөдөлмөрийн орчин
Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
Сургалт, хөгжил
• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
Ажилтнуудын сайн сайхан байдал
Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо
Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ
Байгаль орчин

# Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

- Ажилтнуудынхаа ХАБЭАБО-ы мэдлэгийг нэмэгдүүлж, чадамжийг бэхжүүлэх нь ажлын байрны эрүүл, аюулгүй байдлыг хангахад чухал нөлөө үзүүлдэг. Энэ хүрээнд:
  - Ажлын аюулын дүн шинжилгээний зааварчилгаа,
  - Өндөр эрсдэлтэй ажлыг гүйцэтгэх сэдэвчилсэн сургалт,
  - Даралтат сав, шугам хоолойн аюулгүй ажиллагааны дүрмийн эрх олгох сургалт,
  - Гамшгийн галын аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах дадлага сургуулилт,
  - Аюулыг мэдээлэх аян зохион байгуулсан.

- Төслийн талбайд шинээр ирж буй ажилтнуудын аюулгүй ажиллагааг сайжруулах зорилгоор барилга, цахилгаан, механикийн чиглэлүүдэд тогтмол хийгддэг ажлуудад заавар бэлтгэж, байршуулав.
  - Төслийн бетон цутгалтын ажлын явцад үүсэж болзошгүй эрсдэлийн нөлөөллийг бууруулахад зориулагдсан анхны тусламжийн зөөврийн цүнхийг ашиглахад бэлэн байдлаар хангаж ажиллалаа.

**81,000**

Давхардсан тоогоор ажилтан сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан (Төслийн туслан гүйцэтгэгч ажилтнуудын хамт)

**762**

ХАБЭА-н сургалт, хэлэлцүүлэг, зааварчилгаа (↑)

**556**

Сургалт, хэлэлцүүлэг, зааварчилгаанд зарцуулсан цаг (↑)

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн



Эхлэл
Засаглал
**Нийгэм**
Эдийн засагт оруулсан хувь нэмэр
Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт
Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин
Эрх тэгш хөдөлмөрийн орчин
Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
Сургалт, хөгжил
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
• **Ажилтнуудын сайн сайхан байдал**
Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо
Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ
Байгаль орчин

## Ажилтнуудын сайн сайхан байдал

- Бид ажилтнуудын сайн сайхан байдал, эрүүл мэндэд онцгой анхаарч ажилласан.

- Ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлж, гэнэтийн ослын даатгал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж эрүүл ажлын орчинг сайжруулдаг.
- Шангри- Ла спорт клубт хөнгөлөлттэй үйлчлүүлэх эрх олгох, эрүүл хооллолтын сургалт зохион байгуулах, ашигтай бактерийн хэрэглээг нэмэгдүүлэх, цэвэр усаар хангах болон долоо хоног бүр спорт заалны үйл ажиллагааг хэвшүүлэх зэргээр эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн.
- Тэтгэвэрт гарсан болон одоо ажиллаж буй ахмад ажилтнуудаа хүлээн авч уулзаж, гарын бэлэг олгодог уламжлалтай.
- Хамт олныг нэгтгэх, эерэг уур амьсгалыг нэмэгдүүлэх ач холбогдолтой спортын нэгдсэн өдөрлөг, эрчим хүчний баяр, шинэ жилийн баяр зэрэг олон арга хэмжээг зохион байгуулдаг.
- Өмнөговь аймаг дахь цахилгаан станцын ажилтнуудын амьдардаг Цэций хорооллын 20 байранд бүрэн засвар, үйлчилгээ хийж, ажилтнуудын ая тухтай амьдрах орчинг сайжруулсан.
- Ажилтнууд болон тэдний гэр бүлд Компанийн зүгээс хөнгөлөлт хангамж олгох, сайн сайхны төлөөх ажлуудыг зохион байгуулсаар байна.

**3.5 тэрбум**
төгрөгийг ажилтнуудын сайн сайхан байдалд зарцуулсан (↑)

**652 сая**
төгрөгийн гар утас, байр, хоол, унааны төлбөрийн хангамж (↑)

**1.3 тэрбум**
төгрөгийн бенефитс хангамж (↑)

**913 сая**
төгрөгийн мэргэшүүлэх сургалтын төлбөрийн дэмжлэг (↑)

**606 сая**
төгрөгийн эрүүл мэндийг дэмжих зардал (↑)

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн

Эхлэл
Засаглал
**Нийгэм**
Эдийн засагт оруулсан хувь нэмэр
Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт
Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин
Эрх тэгш хөдөлмөрийн орчин
Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
Сургалт, хөгжил
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
• **Ажилтнуудын сайн сайхан байдал**
Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо
Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ
Байгаль орчин

# Ажилтнуудын сайн сайхан байдал

- Нийгмийн оролцоог дэмжиж, хамт олныг нэгтгэх үйл ажиллагааг идэвхжүүлэн ажилладаг.
  Ажилтны цахим хэрэглээг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн стратегийг гаргаж, суурь ажлыг эхлүүллээ.

  - Хамт олны уур амьсгалыг бэхжүүлэх, ажил амьдралын тэнцвэртэй байдлыг дэмжих зорилгоор "MCS Land" гэр бүлийн өдөрлөгийг зохион байгуулсан.
  - Нийт ажилтныхаа хүүхдүүдэд эрүүл, мэдлэгтэй, хөгжилтэй, хуримтлалтай хүүхдийн баярын бэлэг бэлдэж хүргүүлсэн.
  - Хамт олны нэгдмэл байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах, санал бодлоо чөлөөтэй солилцох уулзалт, үйл ажиллагааг зохион байгуулахад зориулан тодорхой төсвийг баг, нэгжүүдэд олгодог.
  - Өмнөговь дахь цахилгаан станцын ажилтнуудын гэр бүлийн гишүүдийг урьж, үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулснаар гэр бүлийнхэнд компанийн үйл ажиллагааг ойлгох, дэмжих боломжийг олгосон.

**225**
Ажилтанг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан (↑)

**53 сая**
төгрөгийн хангамжийг ажилтны гэр бүлд олгосон (↑)

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн



Эхлэл
Засаглал
**Нийгэм**
Эдийн засагт оруулсан хувь нэмэр
Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт
Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин
Эрх тэгш хөдөлмөрийн орчин
Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
Сургалт, хөгжил
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
Ажилтнуудын сайн сайхан байдал
• **Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо**
Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ
Байгаль орчин



## Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо

- Бид нийгэмд эерэг өөрчлөлт авчрах ажлуудыг хэрэгжүүлэхдээ, ялангуяа ажилтнуудынхаа санаачилгыг дэмжиж, тэдний оролцоог хангахыг чухалчилдаг. Манай хамт олны санаачлан хэрэгжүүлсэн ажлуудаас:

- БЗД-ийн 10-р хорооны зорилтот бүлгийн хүүхдүүдэд шинэ жилийн бэлэг гардуулсан.
- Усны бохирдлыг бууруулах, голын экосистемийг хамгаалах зорилгоор Туул голын ай сав газрын цэвэрлэгээний ажилд идэвхтэй оролцож, шаардлагатай материалыг хандивласан.
- Богд уулын Хүрхрээгийн аманд 11 га талбайд мод тарьж, арчлах үндэсний хөдөлгөөнд санаачлагатай оролцож Байгаль орчныг хамгаалах, ойжуулалтыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан.
- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 7-р цэцэрлэгт 3 сая төгрөгийн үнэ бүхий тоглоом бэлэглэж хүүхдийн хөгжил, сурч боловсрох орчныг сайжруулахад оролцсон.
- Ялгаатай хэрэгцээтэй иргэдэд зориулан бүтээдэг хиймэл эд эрхтэний үндсэн түүхий эд нь усны савны таглаа байдаг бөгөөд ажилтнууд өөрсдийн хэрэглэсэн усны савны таглааг цуглуулан сайн үйлсэд хандив болгон өгдөг.
- Компанийн "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид болон төлөөллүүдэд тайлагнаж, санал хүсэлтийг авч ажиллалаа.

Эхлэл
Засаглал
**Нийгэм**
Эдийн засагт оруулсан хувь нэмэр
Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалт
Нийгмийн хариуцлагатай хөдөлмөрийн орчин
Эрх тэгш хөдөлмөрийн орчин
Хүртээмжтэй хөдөлмөрийн орчин
Сургалт, хөгжил
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
Ажилтнуудын сайн сайхан байдал
Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо
• **Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ**
Байгаль орчин

## Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ

- Компани нийлүүлэлтийн сүлжээндээ тогтвортой буюу байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй нийлүүлэгчид, гэрээт гүйцэтгэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, дотоодын аж ахуй нэгж, харилцагчид болон хөгжлийн бэрхшээлтэй, эмэгтэй бизнес эрхлэгчдийг илүүтэйгээр дэмжихийг эрмэлздэг.

  Худалдан авалтын үйл ажиллагаанд оролцогч талуудад М-Си-Эс Группийн нийлүүлэгчийн портал сайтаар дамжуулан худалдан авалттай холбоотой мэдээллийг нээлттэй хүргэж тэгш боломжоор хангадаг.

- Бид нийлүүлэгч нартаа:
  - Тогтвортой, хариуцлагатай, ёс зүйтэй үйл ажиллагаа явуулах шаардлагыг тавьдаг бөгөөд хамтран ажиллахдаа холбогдох хууль тогтоомж, Компанийн дагаж мөрдвөл зохих хэм хэмжээ, стандартыг чанд мөрдөх зарчмыг баримтлан ажиллаж байна.
  - Нийлүүлэгчийн гүйцэтгэлийн үнэлгээг жил бүр хийдэг бөгөөд сэтгэл ханамжийн судалгаа авч шинжлэн, үйл ажиллагаагаа сайжруулахыг зорьж ажиллалаа.



**90%**

Дотоод худалдан авалт (↑)

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн

Эхлэл
Засаглал
Нийгэм
**Байгаль орчин**
- **Байгаль орчны менежмент**
- Эрчим хүчний хэмнэлт
- Түлшний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарал
- Усны менежмент ба хэмнэлт
- Ногоон байгууламж
- Хог хаягдлын менежмент

## Байгаль орчны менежмент

- Манай компанийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)" -г шингэрүүлсэн хийн түлшээр ажилладаг зуухны үйлдвэрийн онцлогт тохируулан боловсруулж, БОАЖЯ-аар батлуулсан.

- БОМТ-ний дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан. 2023 оны гүйцэтгэл 96%-ийн биелэлттэй үнэлэгдсэн. Үүнд:
  - Орчны тохижилт, ногоон байгууламж,
  - Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө,
  - Хог хаягдлын менежмент,
  - Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр,
  - Удирдлага зохион байгуулалт,
  - Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн.

- Өмнөговь дахь цахилгаан станцын онцлогт уялдуулан БОМТ-г боловсруулж, гүйцэтгэлийг БОНЗ-ын гол оролцогч тал болох Энержи Ресурс компанид тайлагнасан. Үүнд:
  - Станцын уурын зуухны нарийн үнс тээвэрлэхэд үүсэх тоосжилтыг бууруулахаар машины тэвшинд битүүмжлэл хийсэн.
  - Шохойн чулууны системийг ажилд залгах боломжийг судлан, туршилт хийх бэлтгэл хангаж эхэлсэн.

- Мөн ажилтнуудын хариуцлагатай, зохистой хэрэглээг сайжруулах зорилгоор принтерт санамсаргүй, шаардлагагүй хэвлэлт гаргахаас урьдчилан сэргийлсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн.



## Эрчим хүчний хэмнэлт

- Бид үйл ажиллагаандаа Компанийн "Эрчим хүчний бодлого"-ыг баримтладаг. Тайлант хугацаанд эрчим хүчний хэмнэлт (ЭХХ)-ийн тухай хуулийн дагуу Элчит эрчим хүч компаниар хөндлөнгийн аудит хийлгэсэн.
  - Үр дүнд суурилан сайжруулах шаардлагатай ажлуудыг 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
  - Мөн хуулийн дагуу ажилтнуудаа Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ)-ны ЭХХ-ийн менежерийн гэрчилгээ олгох сургалтад хамруулж чадамжийг нэмэгдүүлсэн.
  - 2023 оны ЭХХ-ийн төлөвлөгөөнд 4 ажил тусгаж хэрэгжүүлсэн бөгөөд гүйцэтгэлийг ЭХЗХ-нд тайлагнаж хангалттай буюу 95%-иар үнэлэгдсэн.

  Үүний үр дүнд:
  Эрчим хүч хэмнэх боломжийг судлан, горимын картыг шинэчлэн мөрдөж эхэлснээр 22.5 сая төгрөгийн цахилгаан эрчим хүч (ЦЭХ)-ний бодит хэмнэлт хийгдсэн.

**121**
Мянган МВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн (↑)

**19**
Мянган ГЖ дулааны эрчим хүч үйлдвэрлэсэн (↑)

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн, ↓ 2022 оноос буурсан.

### ЭХХ-ийг илэрхийлэх хэмжүүр:

**86**
МВт.цаг ЦЭХ-ний хэмнэлт (↑)

**9.7%**
Цахилгаан станцын дотоод хэрэгцээний ЦЭХ (↓) < 10%



Эхлэл
Засаглал
Нийгэм
Байгаль орчин
Байгаль орчны менежмент
Эрчим хүчний хэмнэлт
• Түлшний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарал
Усны менежмент ба хэмнэлт
Ногоон байгууламж
Хог хаягдлын менежмент

# Түлшний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарал

- Өмнөговь дахь цахилгаан станцын үйлдвэрлэх үйл ажиллагааны үр ашигтай, хэмнэлттэй байдлыг илэрхийлэх хамгийн энгийн үзүүлэлт бол жишмэл түлшний хувийн зарцуулалт (ЖТХЗ) юм.

  - ЖТХЗ бол станцын хэмжээнд 1 кВт.цаг ЦЭХ үйлдвэрлэхэд зарцуулсан түлшний зарцуулалтыг хэмжих бөгөөд тухайн жилийн зорилтот утгаас 5.2 нэгжээр бага гарсан тул тодорхой хэмжээнд түлшний хэмнэлт хийсэн үр дүнтэй байлаа.

  - Цахилгаан станцын зуухнаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудыг Энержи Ресурс компанийн хяналтад баталгаажсан багажаар хэмжсэн. Үр дүнг MNS 5919: 2008 стандартын зөвшөөрөгдөх хэмжээтэй жишиж, $SO_2$ -ыг дахин бууруулах боломжийг судалж эхлээд байна.

- Байгаль орчинд ээлтэй шингэрүүлсэн хийн түлшээр ажилладаг зуухны үйлдвэр нь жилд хүлэмжийн хийн ялгарлыг 4,783 тонн $CO_2$ хэмжээгээр бууруулдаг.
  - Үйлдвэрийн байгууламж доторх болон гадна орчмын агаарын чанарын шинжилгээг Цаг уур, байгаль орчны шинжилгээний лабораторид улирал тутам хийлгэдэг. Үр дүнгээр MNS 4585:2016 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлагыг хангадаг.

**729**

Гр/кВт.цаг жишмэл түлшний хувийн зарцуулалт < 734 гр/кВт.цаг

**4,783**

Тонн $CO_2$ хүлэмжийн хийн ялгарлыг жилд бууруулдаг

**1,229**

Нүүрстөрөгчийн дутуу ислийн хамгийн их хэмжээ (CO), мг/нм.куб,
(Стандартын зөвшөөрөх хэмжээ: 3,320 мг/нм.куб)

**2,840**

Хүхрийн давхар ислийн хамгийн их хэмжээ ($SO_2$), мг/нм.куб
(Стандартын зөвшөөрөх хэмжээ: 1,740 мг/нм.куб)

**242**

Азотын ислийн хамгийн их хэмжээ ($NO_x$), мг/нм.куб
(Стандартын зөвшөөрөх хэмжээ: 900 мг/нм.куб)

Эхлэл
Засаглал
Нийгэм
Байгаль орчин
Байгаль орчны менежмент
Эрчим хүчний хэмнэлт
Түлшний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарал
Усны менежмент ба хэмнэлт
Ногоон байгууламж
Хог хаягдлын менежмент

# Усны менежмент ба хэмнэлт

- БОНЗ-ын нийтлэг асуудлуудын нэг бол цэвэр усны нөөцийг хамгаалах, үр ашигтай хэрэглэх, хүртээмжийг нэмэгдүүлэх явдал. Иймээс үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагаанд ашиглаж буй цэвэр усыг үр ашигтай хэрэглэхэд анхаарч дахин ашиглах арга хэмжээг хэрэгжүүлсээр байна.
  - Тухайн жилд үйлдвэрлэлд өмнөх жилээс 0.6 тонноор бага буюу 78 тонн гүний усыг хэрэглэсэн.
  - Технологийн хаягдал усыг хиймэл даланд цуглуулдаг бөгөөд усны чанарын үзүүлэлтүүдийг дотооддоо хянаж, MNS 4943: 2018 стандартын шаардлага хангасан үед мод, зам усалгаанд дахин ашигласнаар 20 мянган тонн усыг хэмнэсэн.
  - Ус боловсруулах технологийн хаягдал усыг эсрэг осмосын аргаар дахин цэвэршүүлж 13 мянган тонн усыг хэмнэсэн.

  Усны менежменттэй холбоотой үндэсний стандартуудаас:
  - MNS 4943: 2018 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэрлэгдсэн бохир усны стандарт,
  - MNS 6734: 2018 Дахин ашиглах цэвэрлэсэн ус, техникийн ерөнхий шаардлага,
  - MNS 900: 2018 Ундны усны чанарын стандартыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа баримтлан, дагаж мөрддөг.

**17%**
Дахин цэвэршүүлсэн ус

**26%**
Дахин ашигласан ус



# Ногоон байгууламж

- Өмнөговь дахь цахилгаан станцын орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлж, усалгаа, арчилгаа хийж ургуулах ажлыг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. Тайлант онд үйлдвэрлэлийн бүсэд:
  - 880 гаруй мод, бут сөөг тарьсан бөгөөд ногоон байгууламжийг 0.02 га хэмжээгээр нэмэгдүүлж, усалгааны системээр дамжуулан арчилгааг тогтмол хийж ургуулж байна.
  - Ойжуулах арга хэмжээ нь үйлдвэрлэлийн бүсийн агаарын найрлага дахь хүчилтөрөгчийн хэмжээг нэмэгдүүлж улмаар ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн үр дүнтэй ажил болсон.

**880**

Гаруй мод тарьж ургуулсан (↑)

Тайлбар: ↑ 2022 оноос өссөн



Эхлэл
Засаглал
Нийгэм
**Байгаль орчин**
Байгаль орчны менежмент
Эрчим хүчний хэмнэлт
Түлшний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарал
Усны менежмент ба хэмнэлт
Ногоон байгууламж
• **Хог хаягдлын менежмент**

## Хог хаягдлын менежмент

- Компанийн "Хог хаягдал зохицуулах журам"-ыг мөрдлөг болгодог бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаанаас үүдэн гарсан нөлөөллийг бууруулах, менежментийг сайжруулах чиглэлд дараах ажлуудыг хэрэгжүүллээ.
  - Үйл ажиллагаанаас 253 тонн энгийн хог хаягдал бий болсон. Үүнд, хуванцар, ахуйн хог хаягдал, цаас, мод, цэвэрлэгээний материал багтсан.
  - Аюултай хог хаягдал 16 тонн буюу химийн бодисын хуванцар сав, принтерийн хор, эмнэлгийн хэрэгслийн хог, аккумлятор, тостой материал, дизель түлшний хаягдлууд гарсан.
  - Үүссэн хог хаягдлыг ангилан хаяж, устгах болон дахин боловсруулах эрх бүхий байгууллагуудад гэрээний дагуу шилжүүлж ажилласан.
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, үүсэхээс зайлсхийх арга замыг хэрэгжүүлж байна.
  - Ажилтнуудаас авдаг бүх төрлийн өргөдөл, хүсэлт, зөвшөөрлүүд, ажилтны туршилтын хугацааны үнэлгээ, үнийн саналын хүсэлт, тээврийн хэрэгслийн үзлэгийн хуудас, хэрэглэгчийн санал, гомдол, хүсэлтийн хуудсыг цахим хэлбэрт шилжүүлсэн.
  - МУ-ын хуульд нийцүүлэн, ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээний тоо, давтамжид сайжруулалт хийж цаасны хэрэглээг багасгасан.
  - Ажлын байрны тодорхойлолтыг цахимаар илгээдэг болсон.
  - НӨАТ-ын баримтыг хэвлэхээ больж цахимжуулсан.

**269**

Тонн хог хаягдлыг устгуулсан

**24,000**

Ширхэг цаасны хэрэглээг бууруулсан







MCS интернэйшнл

Манай компани Тогтвортой хөгжлийн тайланг БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамжийн дагуу тайлагнадаг. Тайлангийн мэдээллийг Компанийн дотоод процессын дагуу хянасан бөгөөд тайлант хугацааны байдлаар тогтвортой байдлын талаарх мэдээлэлдээ хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулалт гаргуулдаггүй болно.
Бид энэхүү тайлантай холбоотой санал, хүсэлтийг **info@mcsi.mn** цахим хаягаар хүлээн авахдаа таатай байх болно.

Веб: www.mcsi.mn
Утас: (976) 7722-6262
Хаяг: Монгол Улс, 14241, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла оффис, 7 давхар